

**АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр, Мягмар гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:	1-3
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	4-10
<hr/>	
1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд нэмэлт оруулах тухай/	4-5
2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/	6
3.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/	6-7
4.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/	7-10

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулганы
Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
11 дүгээр сарын 19-ний өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 22 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 54 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Х.Жангабыл, Б.Уянга;
Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Ж.Золжаргал, П.Мөнхтулга, Б.Пунсалмаа;
Эмнэлгийн чөлөөтэй: Д.Үүрийнтуяа.

Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд нэмэлт оруулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар “Байнгын хорооны тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Байнгын хорооны тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 8
Бүгд: 12
33.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Ганбаатар: Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Ганбаатар: “Байнгын хорооны тогтоолд нэмэлт оруулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12
66.7 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 02 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

С.Ганбаатар: “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 3
Бүгд: 13
76.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Гандулам, референт Г.Баярмаа нар байлцав.

Байнгын хорооны дарга С.Ганбаатар “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан, Д.Энхтүвшин, Б.Тулга, П.Ганзориг, Д.Батбаяр нар санал хэлэв.

С.Ганбаатар: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 11 цаг 16 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, ирвэл зохих 22 гишүүнээс 15 гишүүн хүрэлцэн ирж, 68.2 хувийн ирцтэйгээр 11 цаг 17 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

С.ГАНБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан” танхим
10 цаг 54 минут.

АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

С.Ганбаатар: Ирцээ өгчих, бүгд ирчихсэн байна уу? Улсын Их Хурлын гишүүдийн амар амгаланг айлтгая. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Батлут 4 дүгээр тойрог ирсэн байна, С.Ганбаатар 1 дүгээр тойрог ирсэн байна, Даваасүрэн гишүүн 4 дүгээр тойрог ирсэн байна, Жаргалсайхан гишүүн ирсэн байна 1 дүгээр тойрог, Жангабыл гишүүн томилолттой явж байгаа шүү, Мөнхбаясгалан гишүүн 7 дугаар тойрог ирсэн байна, Очирбат гишүүн ирсэн байна, Пүрэвдаваа гишүүн ирсэн байна, Тулга гишүүн ирсэн байна 5 дугаар тойргоос, Үүрийнтуяа гишүүн өвчтэй байгаа, Энхтуяа гишүүн ирсэн байна, Энхтүвшин гишүүн ирсэн байна, Энхцэцэг гишүүн ирсэн байна. Ингээд ирц, Ганзориг гишүүн ирсэн байна, Ганзориг гишүүнийг ирцэд оруулаад ингээд хуралдааны ирц хангалттай хүрсэн учраас өнөөдрийн хуралдааныг эхлүүлъя.

Эрхэм гишүүдийн, өнөөдөр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 11 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя. Ажлын, 1 дүгээрт Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төсөл. Энэ бол Лүндэг гишүүн бас оръё гэсэн санал хэлсэн. Бас энэ Мөнхтулга гишүүн байгаа шүү дээ Эрдэнэс Тавантолгойд оръё гээд, тэрийг дараа нь хэлье. Байнгын хорооны тогтоолын төсөл, 2 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар шалган туслах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ийм Байнгын хорооны тогтоолын төслийг 2 дугаарт батална, хэлэлцэнэ. 3 дугаарт Байнгын хорооны тогтоолын төсөл Эрдэнэс Тавантолгой компанийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах. 4 дүгээрт Байнгын хорооны тогтоолын төсөл Ажлын хэсгийн удирдамж батлах тухай, Тавантолгой түлш компанийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий гэсэн ийм 4 хэлэлцэх асуудал байна.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. Санал байхгүй бол хэлэлцэх асуудалдаа орно.

***Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Байнгын хорооны тогтоолд
нэмэлт оруулах тухай/***

Ингээд хэлэлцэх асуудлын 1 дүгээрт Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэллээ. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуулгын хариуг, асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114.1-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар байгуулсан.

Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллахаар Улсын Их Хурлын гишүүн Лүндэгээс албан бичгээр саналаа ирүүлсний дагуу тус тогтоолд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Ингээд та бүхэнд Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд танилцуулсан, тараасан байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь заалтыг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1. Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны тогтоолын 2024 оны ажлын хэсэг байгуулах тухай 1 дүгээр тогтоолоор баталсан Монголын газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн С.Лүндэг гэж нэмсүгэй. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар.

Тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүд нэрээ өгнө үү? Саналтай гишүүд алга байна. Очирбат гишүүнээр, өөр гишүүд байхгүй бол Очирбат гишүүнээр тасалъя. Очирбат гишүүн микрофонд саналаа хэлнэ үү.

Г.Очирбат: Лүндэг гишүүнтэй холбоотойгоор манай Аж үйлдвэржилтийн байнгын хороонд байхгүй байгаа тийм ээ, байхгүй байгаа гишүүн тийм ээ, байгаа билүү? Тийм үү, Аж үйлдвэржилтийн хороонд байгаа бол санал алга. Байхгүй бол бас санал байсан юм. Тэгэхээр манай Байнгын хороонд байгаа гишүүн бол санал алга.

С.Ганбаатар: Энэ гишүүдийн саналыг ойлгож байна. Энэ нөгөө нэгэнт тогтоол батлагдчихсаны дараа л санал орж ирсэн учраас тогтоолд өөрчлөлт оруулах гэж заавал ч үгүй ингэж орж ирдэг юм байна лээ шүү. Ингээд манай Байнгын хорооны гишүүн юм байна. Санал байхгүй бол, мөн, Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал, энэ саналыг хүчингүй болгоё. Би тийм, нээрээ тийм. Би ирцийн санал нэг хураагаад аваадахъя. Тэгээд зөв. Энэ би бас сая нэг анхаарлаа төвлөрүүлэхгүй юм ярьж байгаад энэ буруу дараад яачихлаа. Саяын саналыг хүчингүй болгох горимын санал гаргаж байна. Горимын санал хураалт явуулъя. Энийг чинь яаж алга болгож байна вэ? Саяын

саналыг хүчингүй болгох горимын саналыг саналаар санал хураалт явуулъя, дэмжье гэсэн томъёоллоор. 66,7 хувиар горимын саналыг дэмжлээ.

Саяын Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалтыг явуулъя. Лүндэг гишүүн манайд. 66,7 хувиар санал дэмжигдлээ.

11.02 цаг

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. Хэлэлцэх асуудлын 2-т Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монголын, Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114.1-д заасны дагуу Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Байнгын хорооны 2024 оны 1 дүгээр тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх ажлын хэсгийн “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төслийг та бүхэнд уншиж танилцуулъя.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3, 22.3.13 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

1.Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор байгуулагдсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн бүтээн байгуулалтын ажлыг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2.Ажлын хэсгийн танилцуулга, санал, дүгнэлт, шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, 9.8 дахь хэсэгт заасны дагуу бэлтгэж, хэлэлцүүлэх мөн тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороонд 2025 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулахыг Улсын Их Хурлын гишүүн, Ажлын хэсгийн ахлагч Л.Мөнхбаясгаланд үүрэг болгосугай. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм тогтоолын төсөл байна.

Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай тогтоолын төсөлтэй холбогдуулж саналтай гишүүд нэрээ өгнө үү? Саналтай гишүүд алга байна. Тогтоолын төслийн талаар саналтай гишүүн байхгүй байгаа тул Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 76,9 хувиар тогтоолын төсөл дэмжигдэж, батлагдлаа. Тогтоолын төслийг 76,9 хувиар дэмжлээ.

11.05 цаг

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Тавантолгой түлш” ХХК-ийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааг шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё. 3 дугаар хэлэлцэх асуудал. Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Тавантолгой түлш компанийн үйлдвэрлэл, технологийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцсэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган туслах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг Байнгын хорооны 2024 оны 2 дугаар тогтоолоор байгуулсан.

Өнөөдрийн хуралдаанаар дээрх ажлын хэсгийн “Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэнэ. Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тарааж, танилцуулсан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан саналтай гишүүд нэрээ өгнө үү? Тогтоолын төсөлтэй саналтай гишүүд алга байна. Тогтоолын төслийн талаар саналтай гишүүд байхгүй байгаа тул Ажлын хэсгийн үйл ажиллагааны удирдамж батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 69,2 хувиар дэмжигдсэн. Протоколд Энхтуяа гишүүн бас дэмжсэнээр, энэ чинь санаачилсан, Ажлын хэсгийн ахлагч учраас дэмжсэнээр санал хурааа гэж протоколд тусгаарай. Саналаа хэлж байна. 69,2 хувиар тогтоол дэмжигдэж, батлагдлаа.

11.07 цаг

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /“Эрдэнэс тавантолгой” ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хэлэлцэх асуудлынхаа 4-д оръё. Эрдэнэс Тавантолгой компанийн ХК-ийн Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу Байнгын хорооны 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг сонссонтой холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах

үүрэг бүхий хяналт шалгалтын ажлын хэсгийг байгуулахаар тогтоолын дагуу тогтоолын төслийг боловсруулж та бүхэнд тарааж, танилцуулсан байгаа.

Тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн болон тогтоолын төсөлтэй холбогдуулан. Ажлын хэсэг байгуулах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг үндэслэн Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооноос тогтоох нь:

Монгол Улсын Их Хурлын Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 116 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцсэнтэй холбогдуулан тухайн асуудлаар шалган судлах, холбогдох санал, дүгнэлт гаргах, шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий хянан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Бүрэлдэхүүнд Д.Энхтүвшин гишүүн Улсын Их Хурлын гишүүн, М.Бадамсүрэн Улсын Их Хурлын гишүүн, Х.Жангабыл Улсын Их Хурлын гишүүн, Ж.Золжаргал Улсын Их Хурлын гишүүн, Г.Лувсанжамц Улсын Их Хурлын гишүүн, Б.Уянга Улсын Их Хурлын гишүүн, М.Энхцэцэг Улсын Их Хурлын гишүүн, Г.Очирбат Улсын Их Хурлын гишүүн гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсгийг баталж байна. Ажлын хэсгийг ахалж Байнгын хорооны дарга миний бие С.Ганбаатар Улсын Их Хурлын гишүүн орж ажиллана.

Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох салбарын мэргэжилтэн, шинжээчдийг оролцуулж ажиллуулахыг ажлын хэсэгт зөвшөөрсүгэй. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга С.Ганбаатар гэсэн ийм Байнгын хорооны тогтоол байна. Тогтоолтой холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? 1, 2, 3, нэрээ өгчих үү? Нэрээ өгчих. Энхтүвшин гишүүний нэр ороорой, кнопоо дараарай. Энхтүвшин гишүүн, Энхтүвшин гишүүнээр тасаллаа. Батбаяр гишүүн орсон уу, та кнопоо, ирцдээ орсон уу? Орчихсон байна. Батбаяр гишүүнээр тасаллаа. Мөнхбаясгалан гишүүн асуулт асууна.

Л.Мөнхбаясгалан: Говийн бүсийн 7 дугаар тойргоос сонгогдсон гишүүний хувиар энэ ажлын хэсэгт орж ажиллах саналтай байна. Дэмжиж өгнө үү.

С.Ганбаатар: Дараагийн, Мөнхбаясгалан гишүүн, Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Энэ нөгөө тогтоолын төсөлтэй холбоотой гишүүдээс санал асуусан юм. Тэгээд Золжаргал гишүүн энэ удаа энд ажлын хэсэгт орохоо больё гэж санал гаргасан. Тэгээд дээр нь Очирбат гишүүн, Далайн Батбаяр гишүүн 2 энэ ажлын хэсэгт орох хүсэлтэй байсан боловч энэ жагсаалтад ороогүй байна. Тэгэхээр энэ 2 гишүүнийг нэмж, Золжаргал гишүүнийг хасвал гэсэн ийм санал байна.

С.Ганбаатар: Ойлголоо, саналыг ойлголоо. Тулга сайд асуулт асууя.

Б.Тулга: Гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг эрье. Тэгэхээр энэ Ажлын хэсэг байгуулах тухай ялангуяа Эрдэнэс Тавантолгойн нүүрс баяжуулах

үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцах ажлын хэсэг байгуулж байгааг 100 хувь дэмжиж байгаа юм 1 дүгээрт. Яагаад гэвэл энэ манай уул уурхайн бүтээгдэхүүнийг нэмүү өртөг шингээсэн, дээр нь бас төрийн өмчийн аж ахуйн нэгж өөрөө энэ үйлдвэрийг хувийн хэвшилд өгөлгүйгээр өөрөө хийсэн нь бол их зөв. Тэгээд энийг зөв гараанд нь гаргаж, төрийн зүгээс болж бүтэхгүй байгаа эрх зүйн орчин гэдэг юм уу, янз янзын зүйлүүд дээр нь дэмжлэг үзүүлэх ийм шаардлага байгаа гэж харж байгаа. Одоо бол туршилтын шугамаар ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

Тэгээд манай гол экспортын боомт Гашуун сухайтаар эдний бараа, бүтээгдэхүүн гарна. Тийм учраас энэ ажлын хэсэгт орж ажиллах хүсэлтэй байна. Нэмж оруулж өгнө үү гэж хүсэж байна. Тэгээд энэ тараасан материал дээр бол Энхтүвшин гишүүнээр ахалж байсан энэ та Ганбаатар гээд өөрийгөө уншсан болохоор Ганбаатар дарга ахалж байгаа гэж ойлголоо. Энхтүвшин гишүүн ажлын хэсэгтэй үлдэж байгаа юм уу? Ойлголоо.

С.Ганбаатар: Ганзориг гишүүн асуулт асууя.

П.Ганзориг: Энэ баяжуулах үйлдвэртэй холбоотой ажлын хэсэг байгуулахыг дэмжиж байгаа. Тэгээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллах саналтай байгаагаа уламжилъя. Баярлалаа.

С.Ганбаатар: Батбаяр, Далайн Батбаяр гишүүн асуулт асууна.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хурлаар орж ирж байгаа Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолтой танилцаж байна. Тэгээд энэ дээр дараах саналтай байна. Юу вэ гэхээр Эрдэнэс Тавантолгой ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр гээд үйл ажиллагааных нь хянан шалгах ажлынх нь хүрээг нь ингээд хумьчихсан байгаад байгаа. Миний санал гэх юм бол энэ Эрдэнэс Тавантолгой гэдэг компани бол зөвхөн баяжуулах үйлдвэр биш, бас нүүрс олборлох, мөн экспортлох, мөн хөрөнгийн commodity бирж дээр борлуулалт хийдэг ийм компани байгаа. Тийм учраас үйл ажиллагааг нь бүхэлд нь хянан шалгах буюу биржид оролцож байгаагаас нь авхуулаад олборлох үйл ажиллагаа явуулж байгаа, мөн тээвэрлэх үйл ажиллагаа явуулж байгааг нь нэмж оруулах ийм саналтай байна. Мөн өөрийнхөө нэрийг энэ ажлын хэсэгт оруулья гэсэн ийм саналтай байна.

С.Ганбаатар: Гишүүд саналаа хэллээ. Батбаяр гишүүний санал их чухал шүү. Энэ анх санаачилсан 3 гишүүний нэг нь Далайн Батбаяр гишүүн байгаа. Тэгээд саяын энэ нүүрс баяжуулах үйлдвэр гэж зүгээр асуудлыг хумихгүйгээр саяын хэлсэн тэр олборлох, биржид үйл ажиллагаа явуулж байгаа болон зарж байгаа бүх үйл ажиллагааг оролцуулна гэдгийг бол манайхан томъёолол дээр оруулах нь байна шүү. Энийг заавал оруулна шүү энэ. Тэгээд яах вэ анх санал гарахдаа бол биржийн асуудлыг тусад нь ярья гэж яриад, тэгээд тэрний бэлтгэл ажлыг хангаагүй гэдгээр явсан хэдий ч гэсэндээ яг энэ Эрдэнэс Тавантолгойтой холбогдуулж энийг бол оруулахаас өөр үггүй шүү. Энийг бас нэг өөмөг цөөмөг дундуур нь оруулж болохгүй. Батбаяр гишүүний саналыг хүлээж авлаа.

Дээр нь нэмээд анх санаачилсан зарим гишүүдээс ахалъя барья гэсэн саналууд гарсан учраас Энхтүвшин гишүүнтэй би шалтгааныг тайлбарлаад, нэгэнт тэгж байгаа бол Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны даргын зүгээс

ахлаад явчихъя гэдэг ийм санал гараад, Энхтүвшин гишүүн ойлгож зөвшөөрсөн гээд ойлголцсон.

Би дахиад нэрсүүдээ уншъя. Ажлын хэсгийг ахалж С.Ганбаатар, Ганбаатар, Д.Энхтүвшин, Бадамсүрэн гишүүн, Жангабыл гишүүн, Золжаргал гишүүнийг бол хаслаа, Лувсанжамц гишүүн, Уянга гишүүн, Энхцэцэг гишүүн, дээр нь нэмээд Мөнхбаясгалан гишүүн, Очирбат гишүүн, Батбаяр гишүүн, Мөнхтулга гишүүн, Тулга сайд, Тулга гишүүн ингээд ороод нийтдээ, Ганзориг гишүүн ороогүй юу, уучлаарай, Ганзориг гишүүн байна шүү, тийм. Ганзориг гишүүн. Ингээд гишүүдийн нэрсийг оруулаад ажлын хэсгээ баталъя гэсэн санал хураалт явуулъя. Ажлын хэсэг байгуулах тухай тогтоолын төслийг баталъя. 71,4 хувиар тогтоолын төсөл дэмжигдэж, батлагдлаа.

11.16 цаг

Өнөөдөр хэлэлцэх ёстой 4 асуудлаа хэлэлцэж дууслаа. Гишүүддээ хандаж хэлэхэд одоо бол удирдамжаа ирэх долоо хоногт дараагийн хуралдаанаар батална. Удирдамжид Батбаяр гишүүнээ энэ дээр чинь манай их туршлагатай олон гишүүд байгаа шүү. Энхтүвшин гишүүн байна, Тулга сайд байна, Очирбат гишүүн байна, Ганзориг гишүүн байна. Олон гишүүд яг энэ дээр удирдамж дээр нэлээн дэлгэрэнгүй оруулчихвал сүүлд нь ажил хэсэг шалгахад их амар байдаг. Гишүүд маань идэвхтэй ажиллаарай. Дараад нь бол газар дээр нь шалгах, материалуудаа цуглуулж авах ажил дээр хамтдаа идэвхтэй ажиллахыг илэрхийлье.

Өнөөдрийн хуралдааныг, Байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон Улсын Их Хурлын гишүүддээ баярлаж байна. Баярлалаа.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Д.УЯНГА